УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2021 оны 12 сарын 21 өдөр Дугаар А/333 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Нийслэлийн 2021 оны төсөв батлах тухай" 02/11 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 2.7, 3 дугаар хэсгийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, 120 мянгатын явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатанд нэмэлтээр халаагч суурилуулж, ажиллуулах ажлын зардалыг хавсралт ёсоор баталсугай.
2. Явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатанд нэмэлтээр халаагч суурилуулж, ажиллуулах асуудлыг дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улаанбаатар Лифт НӨҮГ-аар гэрээгээр гүйцэтгүүлж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хотын Инженерийн байгууламжийн хэлтэс (Т.Хэрлэн)-т даалгасугай.
3. Хавсралтаар батлагдсан ажилд шаардагдах 18 872 016 /Арван найман сая найман зуун далан хоёр мянга арван зургаа/ төгрөгийг Хотын гэрэлтүүлгийн урсгал зардлын хэмнэлтээс санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Цэрмаа)-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ГАНБОЛД

C:\Users\Gantuya\Desktop\ҮЖ 12\doc 2021\тушаал 3.docx

1110301071

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2021 оны 12 дугаар сарын 21 ны өдрийн
А/333 тушаалын хавсралт

Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, 120 мянгатын явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатанд нэмэлтээр халаагч суурилуулж, ажиллуулах ажлын зардал

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, 120 мянгатын явган хүний гүүрэн гарцны цахилгаан шатанд нэмэлтээр халаагч суурилуулж, ажиллуулах ажлын зардал	18 872 016